

БАТИАВ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРАА Т.НЯМ-ОЧИР

“АМЬДРАЛЫН МОД” ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД
ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТЭСЛИЙН
АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго: Сонгогдсон аймаг, дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагад “Амьдралын мод” сургалтын модуль, хэрэглэгдэхүүнийг ашиглан сургалт, үйл ажиллагааг цахим систем нэвтрүүлэн зохион байгуулж үр дүнг тооцож, цэцэрлэгийн менежментийг сайжруулна.

Хамрах хүрээ: Сонгогдсон аймаг, нийслэлийн нийт 85 цэцэрлэг хамрагдана. Үүнд:

- ✓ Нийслэлийн Хан-Уул дүүргийн сонгогдсон 37 цэцэрлэг
- ✓ Орхон аймгийн сонгогдсон 30 цэцэрлэг
- ✓ Хөвсгөл аймгийн сонгогдсон 18 цэцэрлэг

Хугацаа: Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 60 хоног байна.

Зохион байгуулалт:

- ✓ Сонгогдсон аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, дүүргийн Боловсролын хэлтэс, цэцэрлэгийн удирдлагуудад зөвлөмж, чиглэл хүргүүлнэ.
- ✓ Сонгогдсон цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд сургалтын цахим системийг нэвтрүүлнэ.
- ✓ Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нар, эцэг эх, асран хамгаалагчдад сургалтын цахим системтэй хэрхэн ажиллах талаар арга зүйн дэмжлэг узүүлэх сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулна.
- ✓ Цэцэрлэг бүрийн хэрэгжүүлж буй үйл явцтай танилцаж, зөвлөн тусална.
- ✓ Цахим систем дэх мэдээллийг нэгтгэж үр дүнг тооцож ба тайлагнана.

Хүрэх үр дүн:

- ✓ Сургалтын цахим системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж хэвшина.
- ✓ Хамрагдах цэцэрлэгийн бүх арга зүйч, багш нар систем дээр хэрэглэгчийн эрх эзэмшиж, хэрэгжилтийн яяцэд цахимд сууринсан үнэлгээг хийсэн байна.
- ✓ Багш нар хүүхдийн хөгжлийн явцын болон үр дүнгийн үнэлгээг цахим системд суурilan хийх арга барилд суралцана.
- ✓ Хэрэгжилтийн хугацаанд хийгдсэн хүүхдийн хөгжлийн үнэлгээний үр дүнг боловсруулж хүүхдийн тайлан үссэн байна.
- ✓ Хүүхдийн хөгжлийн тайланг эцэг эх, асран хамгаалагчидад илгээсэн байх ба ингэснээр цэцэрлэг, багш, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагаа сайжирч, байгууллагын хөгжилд ашиг гарна.

Үйл ажиллагаа:

Нэг: Сургалтын цахим системийн үйлчилгээ:

1. Сургалтын цахим систем нь сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаанд нийцэн байх ба Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/280 дугаар журмын дагуу багш хүүхдийн хөгжлийн үнэлгээ

хийх боломжийг бурдүүлсэн байх ба танилцуулга, ашиглах заавар, систем рүү нэвтрэн орох туршилтын эрхийн хамт бэлтгэн ирүүлэх

2. Сургалтын цахим систем нь эцэг эх, асран хамгаалагч, багш, арга зүйч гэсэн олон хэрэглэгчдэд зориулагдсан бүтэцтэй байх бөгөөд хэрэглэгчид нь өөрийн нэвтрэх нэр, нууц угзэр нэвтрэх боломжтой байх.
3. Сургалтын цахим систем нь бүх төрлийн төхөөрөмжөөс нэвтэрч орох, ашиглах боломжтой байх ба гар утасны аппликацийн тайлбарын мэдээллийн үр дүн болгож боловсруулдаг шийдэлтэй байх
4. Сургалтын цахим системд оруулсан хүүхдийн хөгжлийн үзүүлэлтийн мэдээллийн үр дүн болгож боловсруулдаг шийдэлтэй байх
5. Сургалтын систем нь хамгийн багадаа 30,000 хэрэглэгчийг хамруулах хүчин чадалтай байх
6. Систем нь хэрэглэгч цэцэрлэгийн үйл ажиллагаанд зориулсан тохируулгыг хийх боломжтой байх. /Хөтөлбөрт нийцсэн үнэлгээний загвар, рубрик, контент удирдах, үнэлгээний болон үйл ажиллагааны хяналт, явцын тайлан гэх мэт/

Хоёр. Сургалт зохион байгуулах үйлчилгээ

1. Гүйцэтгэгч нь төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх тухайн байгууллагаас хэрэгжүүлэх боломж бүрдсэн эсэхийг илрүүлэх байдлыг тогтоох судалгааг авах асуултгыг боловсруулан ирүүлэх
2. Гүйцэтгэгч нь өөрийн санал болгож буй систем, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтыг аймаг, дуурэг бүрийн удирдах ажилтан, багш наарт хамгийн багадаа 2 удаа удирдан зохион Байгуулах ба удирдамж, хөтөлбөрийг боловсруулан ирүүлэх
3. Гүйцэтгэгч нь цэцэрлэгийн эцэг эх, авсан хамгаалагчдад сургалтын цахим системтэй хэрхэн ажиллах талаар аргачлалыг танилцуулах сургалтыг сонгогдсон аймаг, дуурэг тус бурд хамгийн багадаа 2 удаа зохион Байгуулах ба удирдамж, хөтөлбөрийг боловсруулан ирүүлэх

Гурav. Хиний нөөцийн тавигдах шаардлаза

1. Санал болгож буй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх баг нь 7 ба түүнээс дээш гишүүдээс бүрдсэн бэйх
2. Хамгийн багадаа 4 гишүүн нь БШУ-ын сайдын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/ индекс шинэчлэлийн батлах тухай” А/160 дугаар тушаалын дагуу “Багш, сургуулийн өмнөх боловсрол” нарийвчилсан чиглэлийн 011201 гэсэн индексийн бакалаврын дипломтой байх
3. Төслийн багт мэдээллийн систем, программ хангамжийн 2-оос доошгүй гишүүн оролцсон байх
4. Санал болгож буй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багийн гишүүдийн товч CV/мэдээллийг ирүүлэх.